

FRONT~~EX~~X

EURP

ЕХ-НЫ БУЦААН
БАЙРШУУЛАХ ХӨТӨЛБӨР

ЦАГААЧДЫГ ЭРГЭН СУУРЬШИХАД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ

Фронтекс дэх эргэн суурьшуулах
хөтөлбөрийн хамтын
ажиллагааны хүрээнд



МОНГОЛ ХУВИЛБАР

Бид танд тусламж дэмжлэг
үзүүлнэ

САЙН ДУРААР НУТАГ БУЦАХ НЬ ЯМАР ДАВУУ ТАЛТАЙ ВЭ?

Эх орондоо буцаж очих нь хэцүү байдаг гэдгийг бид ойлгож байна. Бид танд тусламж дэмжлэг үзүүлнэ. Бид таныг аян замдаа гарахад тань тусалж, таныг буцаж очиход танд ямар боломж байх талаар мэдээлэл өгөх болно.

Та сайн дураар нутаг буцахаар шийдсэн эсвэл Гишүүн улсын үндэсний эрх бүхий байгууллагуудаас буцах шийдвэр хүлээн авсан бол эх орондоо эргэн суурьшихад тусламж дэмжлэг авах эрхтэй байж болно. Европын хил болон эрэг хамгаалах агентлаг болох Frontex нь таны эх нутаг дахь иргэний нийгэмлэгийн байгууллагуудтай хамтарч **Эргэн суурьшуулах хамтарсан үйлчилгээ** нэртэй хөтөлбөр боловсруулсан. Эдгээр байгууллага нь эргэн суурьшихад түслалцаа үзүүлэх чиглэлээр туршлагатай бөгөөд эх орондоо дахин шинээр эхлэхэд тань туслахад бэлэн зогсдог юм.

ТАНД БУЦАХ ҮЙЛ ЯВЦ ТӨВӨГТЭЙ МЭТ САНАГДАЖ МАГАДГҮЙ ЮМ. БУЦАХАД ОЛОН АСУУЛТ ТӨРЖ, СЭТГЭЛИЙН ТАВГУЙ БАЙДАЛ ҮҮСЭЖ БОЛНО. ТАНД ТЭДГЭЭР ХАРИУЛТАА ОЛОХОД ТАНЬ ТУСЛАХААР ЭРГЭН ИРЭХ БОЛОН СУУРЬШИХАД ТУСЛАХ ЗӨВЛӨХ БУЮУ МЭРГЭШСЭН АЖИЛТНУУД ТАНЫ МЭДЭЛД БАЙХ БОЛНО. ТЭД ТАНЫГ ЭРГЭН ИРЭХ, СУУРЬШИХ ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН, ЗАХИРГААНЫ БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ТАЛААС НЬ ДАМЖУУЛАН ИРЭЭДҮЙДЭЭ ЗӨВ СОНГОЛТ ХИЙХЭД ТАНЬ ТУСЛАХ БОЛНО.

Хэрэв танд тусгай хэрэгцээт үйлчилгээ хэрэгтэй бол, жишээлбэл та харгалзах хүнгүй насанд хүрээгүй иргэн бол эсвэл жирэмсэн эмэгтэй бол, хүний наймааны хохирогч бол, эрүүл мэндийн асуудалтай тусгай хэрэгцээт иргэн бол, эсвэл хүүхэдтэй хамт явах гэж байгаа бол Эргэн ирэх болон суурьшихад туслах зөвлөхдөө мэдэгдэнэ үү. Зөвлөх нь таны хувийн эрүүл мэнд, холбогдох нөхцөл байдлыг харгалзан үзэж таны эргэн суурьших тусламж дэмжлэгийн төрөлд илүү нийцүүлэн тусламж дэмжлэг үзүүлэх болно.

БИ ЭРГЭН СУУРЬШИХАД ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ АВАХ ЭРХТЭЙ ЮУ?

Та дараах тохиолдолд эргэн суурьшихад тусламж дэмжлэг авах эрхтэй:

- a. Та үлдэх, хууль ёсоор оршин суух эсвэл/болон олон улсын хамгаалалт (орогнол хүсэх) авах хүсэлтдээ **эцсийн татгалзсан шийдвэрийг хараахан хүлээж аваагүй** бөгөөд та эргэж ирэхээр шийдсэн. Ийм тохиолдолд **сайн дураар буцах** тухай яригдана.
- b. Та Гишүүн улсын нутаг дэвсгэрээс гарах ёстой эцсийн хугацааг тогтоосон 'буцах шийдвэр' буюу/эсвэл эцсийн татгалзсан шийдвэрийг хүлээн авсан. Та эх орондоо буцах шийдвэрийг гаргасан. Ийм тохиолдолд **сайн дураар** буцах боломжтой. Таны оршин суугаа Европын улсын эрх бүхий байгууллагуудаас эргэн суурьших тусламж авах боломж болон тухайн улсаас гарах эцсийн хугацааны талаар танд мэдэгдэх болно.

**ХЭРЭВ ТА ЕХ-НЫ ГИШҮҮН ОРНЫ
НУТАГ ДЭВСГЭРТ ҮЛДЭХ, ХУУЛЬ
ЁСООР ОРШИН СУУХ БОЛОН/ЭСВЭЛ
ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТЫГ
ЭДЛЭХ ЭРХТЭЙ БОЛ ТА ЭРГЭН
СУУРЬШУУЛАХ ТУСЛАМЖ АВАХ
ЭРХГҮЙ БОЛНО.**

- c. Та б-д тайлбарласны дагуу **буцах шийдвэр хүлээн авсан** бөгөөд заасан эцсийн хугацаанд (сайн дураар явах) явахаар сонгоогүй бол. Ийм тохиолдолд буцах шийдвэрээр албадан гаргах бөгөөд таныг хүчээр гаргахыг та хүлээн зөвшөөрч буй болно.

Эргэн суурьшуулах хамтарсан үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргах үед ЕХ-ны гишүүн орнууд үндсэн хуулийнхаа дагуу таныг эргэн суурьшихад тусламж авах эрхтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй гэдгийг **анхаарна уу.**

ЭРГЭН СУУРЬШИХ ЯМАР ТӨРЛИЙН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ БАЙДАГ ВЭ?

Эргэн суурьшуулах хамтарсан үйлчилгээ нь хоёр төрлийн тусламж дэмжлэгээс бүрдэнэ:

Богино хугацааны тусламж дэмжлэг: Таныг ирсэн даруйд онгоцны буудлаас тосож авах, богино хугацаанд байрлах байраар хангах, эмнэлгийн тусламж үзүүлэх, орон нутгийн тээврээр хангах, гэр бүлтэй нь үүлзүүлэх, санхүүгийн /хязгаарлагдмал/ тусламж үзүүлэх зэрэг хэлбэрээр эхний хэдэн өдөр танд яаралтай тусламж үзүүлэх боломжтой.

Урт хугацааны тусламж дэмжлэг: Эргэн суурьших төлөвлөгөөг 12 сар хүртэлх хугацаанд гаргаж болно. Таны оршин суух улс дахь Эргэн суурьшихад туслах зөвлөх болон таны төрсөн нутагт байх манай байгууллага танд хамгийн сайн тохирох сонголтын талаар тантай ярилцаж, таныг эх орондоо буцсаны дараа хийх боломжит төлөвлөгөөг хамтран хийнэ. Урт хугацааны дэмжлэгийн жишээнүүд:

Урт хугацаагаар амьдрах байр болон холбогдох зардал

Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Боловсрол (сургууль, мэргэжлийн сургалт)

Ажлын зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлд ороход тань туслах

Жижиг бизнес эрхлэхэд туслалцаа үзүүлэх

Гэр бүлтэй нь холбож, үүлзүүлэх

Хуулийн зөвлөгөө өгөх, захиргааны дэмжлэг үзүүлэх

Сэтгэлзүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх

Эргэн суурьшуулахад туслах хамтрагч танд аль ч тохиолдолд зохих дэмжлэг үзүүлэх бөгөөд тэд таны эргэн суурьших төлөвлөгөөг хянаж, бусад мэргэжлийн байгууллагуудтай таныг холбож өгөх зэргээр туслах боломжтой.

БИ ЭРГЭН ИРЭХ БОЛОН СУУРЬШИХАД ТУСЛАХ ЗӨВЛӨХӨӨСӨӨ ЮУ ХҮЛЭЭЖ БОЛОХ ВЭ?

Эргэн ирэх болон суурьшихад туслах зөвлөхтэйгөө хийх ганцаарчилсан зөвлөгөөний үеэр танд нутаг буцах боломж болон эргэн суурьших тусламж, дэмжлэгийн сонголтуудын талаар хэрэгтэй мэдээлэл өгөх болно. Зөвлөх тань танд тусламж дэмжлэг үзүүлэхээр бэлтгэгдсэн байдаг бөгөөд танд байж болох бүх асуултад хариулах болно. Та Эргэн ирэх болон суурьшихад туслах зөвлөхөөсөө таны гаргасан өргөдөлтэй холбоотой ямар эрхүүд байдгийг хүссэн үедээ асуух боломжтой. Танд зөвлөгөө өгөх үеэр зөвлөхтэйгөө адил хэлээр ярихад хүндрэлтэй санагдвал та орчуулагч авахаар хүсэлт гаргаж болно.

Хэрэв та эргэн суурьшихад дэмжлэг авах сонирхолтой байгаагаа илэрхийлбэл, Зөвлөх таны өргөдлийг боловсруулах үүднээс таны хувийн мэдээллийг авах шаардагатай. Та өөрийн биеийн байцаалт болон гэр бүлийн гишүүдийнхээ холбогдох мэдээлэл, тэдний хаана байдаг талаарх мэдээллийг өгөх шаардлагатай. Танаас авсан мэдээллийг ашиглахдаа хувь хүний нүүцыг хамгаалах журмын мөрдлөг болно. Аливаа тусгай хэрэгцээ байгаа бол эргэлзэхгүйгээр Зөвлөхдөө мэдэгдэнэ үү.

Өргөдөл гаргах явцад танаас маягт бөглөх болон таны хувийн мэдээлэлтэй харьцах зөвшөөрлийг Фронтекс-д өгөхийг хүсэх болно. Энэхүү мэдээлэл нь таныг мөн болохыг баталгаажуулахад Эргэн суурьшуулах төслийн хамтрагчид хэрэгтэй бөгөөд зөвхөн энэ зорилгоор Европын холбооны мэдээлэл хамгаалах ерөнхий журмын дагуу ашиглагдана.

ТЭМДЭГЛЭЛ

БИ (ОРОН НУТГИЙН) ЭРГЭН СУУРЬШУУЛАХАД ТУСЛАХ ТҮНШЭЭС ЮУ ХҮЛЭЭЖ БОЛОХ ВЭ?

Таны төрсөн газрын Эргэн суурьшуулахад туслах түнш таны хэргийг хариуцах болно. Та богино хугацааны тусламж дэмжлэг авахыг хүссэн бол түнш таныг нисэх онгоцны бүүдлаас түнш тосон авч, хамгийн хэрэгцээт зүйлээр тань туслах болно. Хэрэв та удаан хугацааны тусламж дэмжлэг авахаар сонгосон бол манай эргэн суурьшуулахад туслах түнш тантай холбоотой байх бөгөөд та асуултдаа хариулт авах боломжтой. Манай түнштэй холбогдох нь танд үргэлж нээлттэй байх болно. Хэрэв асуух ямар нэг зүйл байвал Эргэн суурьшуулахад туслах түнштэй холбогдож, идэвхтэй байна үү.



АНХААРАХ ЗҮЙЛС:

Эргэн суурьшуулахад туслах түнш эсвэл түүний орон нутгийн түншүүд танд ажлын цагаар туслалцаа үзүүлэх болно.

Эргэн суурьшуулахад туслах түнш эсвэл орон нутгийн хамтрагчтай зүй бүс харьцах, хүндрэл учруулахыг хориглоно.

Эргэн суурьшуулахад туслах орон нутгийн хамтрагч таны бүх асуудлыг шийдэж чадахгүй; тэд өмнө нь хэлэлцэж тохиролцсон тусламж дэмжлэгийг л үзүүлэх заалттай.

Өргөдлийг эхлүүлэхийн тулд танд биеийн байцаалтын бичиг баримт хэрэгтэй

Та өргөдлийг эцэслэхийн тулд зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурах шаардлагатай.

ТА ӨӨРИЙН УЛСЫН ЭРГЭН СУУРЬШУУЛАХАД ТУСЛАХ ТҮНШТЭЙ ХОЛБОО БАРИНА УУ

Дараах вебсайтаас
бүх мэдээллийг
авах боломжтой →

